НОЁНЫ 10 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА Ц.БЯМБАТОГТОХЫН 2024 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

2024 оны 11 дүгээр сарын 22 — Арвайхээр сум

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. "Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **1.1** Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх. | Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хувиар | 90% | 100% | ЗГ-ын 2023 оны Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 119-р тогтоол, Аюулгүй иргэн Амар тайван Өвөрхангай" дэд хөтөлбөр, сумын Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн тогтоол шийдвэрийг хяналтад аван хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 01-11сар | 100 |
| | **1.2** "Нээлттэй Өвөрхангай" хөтөлбөрийг сурталчлах. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас шилжин ирж байгаа өрхийн хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 1 | Шилжин ирсэн өрийн хүүхдүүдийг 100 хувь боловсролын үйлчилгээнд хамруулсан. | 01-11 сар | 50 |
| | | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 90% | 100% | Энэ онд 51 өрхийн 145 иргэн шилжиж ирснээс 8 иргэн Улаанбаатар хотоос шилжиж ирсэн байна. Төрийн байгууллагат 3, хувийн хэвшилд 2, бага насны хүүхдээ хардаг гэрийн ажилтай 3 эх байна. | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулах. | | | | | | |
| | **1.2.1** Сул ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй хүртээмжтэй хэлбэрээр хүргэх. | Иргэдэд хүргэсэн зарын тоогоор | 10 | 10 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон хувийн хэвшил аж ахуй нэгжээс ирсэн түр болон бүр ажлын байны зарыг Noyon Arvaikheer гэсэн фэсбүүк, хэсгийн ахлагчийн болон 10 дугаар багийн иргэд гэсэн 450 иргэнтэй групп чатуудад нээлттэй оруулж сонирхсон иргэдийг холбон зуучилж ажилладаг. | 01-11 сар | 100 |
| | | Ажилд зуучлагдсан иргэдийн тоогоор | 3 | 5 | 2024 оны жилийн эцсийн байдлаар түр ажлын байранд 22 иргэн, бүр ажлыг байранд 20 иргэн зуучлагдан ажилласан байна. | 01-11 сар | 100 |
| | **1.3** "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтод жилийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 100% | Сумын "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жилийн хүрээнд баг 3 бүлэг 11 зорилт арга хэмжээний төлөвлөгөөг багийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна.<br>"Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтот жилийн хүрээнд Иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэх анхан шатны сургалтад хамрагдаж сурагч багшаар бэлтгэгдсэн.<br>Иргэд www.e-mongolia.mn веб портал болон "E-Mongolia" гар утасны аппликейшн ашиглаж аль нэг төрийн байгууллагыг зорьж очилгүйгээр, өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг гэрээсээ эсвэл ажил дээрээсээ ямар ч цаг үед авч болох боломжийг "E-Mongolia" олгож байх талаар иргэдэд мэдээлэн ажиллаж байна.<br>Багт EMongolia цахим системийг ашиглан 64 иргэн цэргийн бүртгэлээр бүртгүүлсэн, 53 иргэн EMongolia цахим системийг ашиглан ОНХСанд цахимаар саналаа өгсөн байна.<br>2024 оны 3-р сард малчин өрхөд Засгийн газар, Улсын онцгой комиссоос хөнгөлөлттэй үнээр өвс тэжээл өгч Багийн нэгдсэн төвийн зааланд сургалт зохион байгуулсан.Сургалтад багийн 45 малчин оролцож Эрсдэлгүй Өвөрхангай апп-ыг сурталчилж, What 3 words апп-ыг сурталчлан иргэдэд ашиглалтыг заан өгч ажилласан.<br>Тоон гарын үсэг хэрэглээнд нэвтэрч эхэлснээр цаг хугацаа, | 01-11 сар | 100 |

161

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орон зайнаас үл хамааран хоорондоо цахим хэлбэрээр гэрээ хэлцэл хийх, албан байгууллагад өргөдөл, гомдол гаргах, банк санхүү, даатгалын байгууллагуудтай цахимаар харилцах гэх мэт олон боломжууд нээгдэж ач холбогдолтой талаар иргэдэд тайлбарлан өгөн ажиллаж байна.<br>2024 онд шилжиж ирсэн 18-аас дээш насны 32 иргэнийг Арвайхээр сум хариуцсан улсын бүртгэгч рүү явуулж тоон гарын үсгийг авхуулан хамтран ажилласан .<br>Ноёны 10 дугаар баг нь цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, шинэчилсэн хууль, тогтоомж, төрийн үйлчилгээг цахимаар авах чадварыг эзэмшүүлэх, эрүүл мэндийн зөвлөн туслах үйлчилгээг хүргэх зорилготой нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 51 иргэн эрэгтэй 14, эмэгтэй 37 иргэн оролцсон.<br>Багийн Noyon Arvaikheer facebook хаяг, 10-р багийн иргэд чат группд Зорилтот жилийн ажлын хүрээнд Цахим хөгжлийн яамнаас гарсан контент, Аймгийн ЗДТГазар, Сумын ЗДТГазар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас гарсан конттент, шторк, цахим орчинд сурталчлан ажиллаж байна. | | |
| | **1.4.** “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг хангаан ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 3 | Магнай трейд шатахуун түгээх станцаас урагшаа явсан засмал зам дагуу 2-2,5 м өндөртэй 450 ш хайлаас модыг Цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГазартай хамтран нөхөн тарилт хийсэн.<br>Баян намсрай цэцэрлэгт хүрээлэнд энэ онд нэмэлтээр хүрээлэнгийн тохижилтын зураглалын дагуу ургамлан хашлагаар мод бут тарих ажлыг 140 төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжүүд 8300 ш мод бут, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар -8519 нийт 16819 ширхэг 5 нэр төрлийн мод бут таригдсан бөгөөд амьдралт 83 хувь байна | 01-11 сар | 100 |
| | | Ногоон байгууламж | 250 | 300 | Мөн багийн иргэн Түвдэнпүрэв хүйс толгойн ард шинээр газар авч улиас хайлаас, монос, үхрийн нүд, чацаргана, | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлсэн өрхийн тоогоор | | | бургас, нарс зэрэг 250 ш мод хашаандаа тариалсан. Багаас 20 иргэнд улиас 40, агч 20 ширхэг мод үнэгүй өгч тариулсан. | | |
| | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан өрхийн тоогоор | 15 | 40 | 18 хэсгийн ахлагч, 22 иргэнийг мод бут тариалах сургалтад хамруулж иргэд айл өрхүүдэд мэдээлэл өгүүлж ажиллаж байна. | 01-11 сар | 100 |
| | **1.5** Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж нэгдсэн хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 0 | 4 | Нийтийн их цэвэрлэгээг багийн нутаг дэвсгэрт 3 удаа зохион байгуулж 30 тн хог цэвэрлүүлж хогийн цэгт хүргүүлсэн. Давхардсан тоогоор 180 гаруй иргэн оролцсон. Тайланг тухай бүр ХЗАлбанд хүргүүлсэн. | 01-11 сар | 100 |
| | | Сургалт, мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоогоор | 42 | 45 | Сар бүрийн 5-8, 21-26-ны хооронд хог ачилтын хуваарийг багийн групп чат, Noyon Arvaiheer фэсибүүк хаягуудад оруулж хуваарийн дагуу ажилт хийгдэж, хог ачилттай холбоотой гомдол санал бүрэн шийдвэрлэгдсэн. | 01-11сар | 100 |
| | **1.6** Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 2 | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн мэдээллийн санд 3-15 квт хүчин чадалтай 859 өрх, усан халаалтын 15-100 квт чадалтай зуухтай 2 нийт 861 өрхийн судалгааг өгөгдсөн маяг загварын дагуу гарган баяжилт хийн программд шивж оруулав. | 01-11 сар | 100 |
| | | Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн хувиар | 10% | 15% | Сайжруулсан шахмал түлшийг 2 цэгт борлуулж байгаа бөгөөд нийт өрхийн 5 хувь нь буюу 47 өрх хэрэглээндээ нэвтрүүлж Баянтээг ХХК-с нийлүүлсэн тоо хэмжээгээр хэрэглээндээ нэвтрүүлж байгаад 2 дугаар сард үйлдвэрлэсэн нөөц дууссан. Байшинг халаахдаа муу үнс их гардаг гэсэн гомдол ирсэн. | 01-11 сар | 100 |
| | | Шинээр эко, болон | 8 | 10 | 18 өрхөд эко-00 хийлгэсэн. | 01-11 | 100 |

165

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулсан нойл, муу усны цооногтой болсон өрхийн тоогоор | | | | сар | |
| | **1.7** Малчдын "Аравтын бүлэг"-ийг чадавхжуулах ажил зохион байгуулах, бүлгийн тоог нэмэгдүүлэх. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | 1 | Монгол улсын Засгийн газраас улс орон даяар хэрэгжүүлж байгаа Шинэ хоршоо хөдөлгөөний сургагч багш орон нутагт ирж ажиллаж байгаатай холбогдуулан багийн 100 гаруй малчин өрхүүдэд хоршооны тухай мэдээлэл ойлголт өгүүлж ажилсан. | 01-11 сар | 100 |
| | | Чадавхжсан Аравтын бүлгийн тоогоор | - | 1 | "Шинэ хоршоо" хөдөлгөөн арга хэмжээний хүрээний 14 малчин өрх гишүүнээр элсэн орж, бэлчээр хаших, ногоон тэжээл тариалах, зэрэг үйл ажиллагаануудаа эхлээд явж байна. Мөн Аймгийн ХАА-н газраас зохион байгуулсан Шинэ хоршоо арга хэмжээнд Баянтүмэн аравтын бүлийн гишүүн Т.Мөнгөн, Ц.Бямба нарыг оролцуулсан.<br>Энэ онд 3 залуу малчин өрхийг малжуулах төсөлд хамруулж 24,000,000 төгрөгийн мал олгуулсан. | 01-11 сар | 100 |
| | **1.8** Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | Өвөлжилтийн төлөвлөгөөг 6 арга хэмжээний хүрээнд боловсруулан Сумын Засаг даргын орлогчоор 8-р сад батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж 11 сарын 20 нд биелэлтийн тайланг гаргаж ХАА-н тасаг өгсөн. | 01-11 сар | 100 |
| | **1.9** Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес эрхлэгчдийг төсөл | Төсөл хөтөлбөрт зуулчилж, сургалтад хамруулсан тоогоор | 3 | 5 | Аймгийн ХХҮГазраас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд шаардлага хангасан иргэдийг уламжлан ажилладаг. Нийтийг хамарсан 22 иргэнийг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 3 иргэн, ахмад настны зөвлөн туслах үйлчилгээнд 8 ахмад, ХБИргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 2 иргэн, малжуулах | 01-11сар | 100 |

164

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн сургалтад хамруулах, зуулчлах. | | | | төсөлд 3 малчны тус тус хамруулсан. | | |
| **Зорилт 2. “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах”** | | | | | | | |
| 2. | **2.1.** Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг хангах ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 1-р улиралдаа шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 67, 2011 оны 339, 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль 2024 оны 04 дугаар сарын 25 ний 16.00 цагт ЕБ-ын 5-р сургуулийн гаднах талбайд цугларч дадлага ургуулалтад багийн 85 иргэн, ЕБ-ын 5 дугаар сургуулийн 25 багш, ажилчид 600 гаруй сурагч, 26 авто машин тээврийн хэрэгсэл оролцож, аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчдын гамшгийн үеийн бэлэн байдлын талаарх сургалт мэдээллийг өгүүлж, арга хэмжээний мэдээг Аймгийн ОБГазарт хүргүүлэн ажилласан. | 01-11 сар | 100 |
| | **2.2.** Өвөрхангай аймгийн анх шатны Улаан Загалмай хороотой хамтран ажиллах. | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүдүүд элсүүлсэн иргэний тоогоор | 2 | 5 | Монголын Улаан Загалмайн хорооноос Зохион байгуулсан Анхны тусламжийн сургалтад багаас 5 сайн дурын идэвхтэн, багийн Нийгмийн ажилтан нарыг Улаанбаатар дахь Хүүхэд Залуучуудын төвд болсон сургалтад хамруулсан. Мөн эхний хагас жилийн байдлаар 3 малчин, 1 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг Аймгийн Улаан Загалмайн хорооны онцгой гишүүнээр элсүүлсэн. Мөн энгийн гишүүнээр 2 иргэн элсүүлсэн. | 01-11 сар | 100 |
| | **2.3.** Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах. | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 87% | 100% | Нарны дөш” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 12 арга хэмжээ төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 01-11 сар | 100 |
| | | Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар | 25% | 30% | 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага болсонтой холбогдуулан цэргийн насны 115 залуусыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахын ач холбогдлыг таниулах сургалтад 10 бүсгүйчүүлийг хамруулсан. Ахмад | 01-11 сар | 100 |

165

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төслөөр сургагч багш Ц.Ишээхүү нь "Нарны Дөш өрхийн эрүүл мэндийн төв, багийн ажлын албатай хамтран 7 хоногт 3 удаа өглөө 7 - 9 цагийн хооронд ХИЙН ДАСГАЛ хийж хэвшсэн. Эрүүл зөв хооллолт, ӨЭМТөвөөр анхны тусламжийн үйлчилгээ авч байгаа иргэдэд эрүүл насжилтын сургалт зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Багийн байнгын асаргаанд байдаг 54 ахмад настан байдгаас гэрийн асаргаа сувилгаанд 5 ахмад настныг хамруулах ажлыг өрхийн эмнэлэгтэй хамтран явуулсан. | | |
| | **2.4.** Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах. | Гэрээний хэрэгжилтийн хувиар | 80% | 80% | Малын эмч Д.Бадамхандтай гэрээ байгуулан ажиллаж малчин, мал бүхий иргэдийн малыг хугацаатай вакцин туулгалтанд бүрэн хамруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын сохор, догол болон бусад халдварт өвчин гараагүй байна. 112 малчин 36 мал бүхий өрхийн нийт 27029 толгой мал тоологдсоноос адуу 1831 толгой, үхэр 1201 толгой, тэмээ 13, хонь 14882 толгой, ямаа 9102 толгой малын судалгааг гаргаж сумын ХАА-н тасагт өгч 3-н чиглэлийн малын эмч нараар 100 хувь вакцинд хамруулан ажилласан байна. | 01-11 сар | 100 |
| | **2.5.** Хагас жил болон жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд программд оруулах. | Мэдээг мал тооллогын программд алдаагүй үнэн зөв оруулсан хувиар | 100% | 100% | Улсын хэмжээнд зохион байгуулагддаг хагас жилийн түүвэр тооллогыг зүүн чиглэлд Арвайхээр сумын 10 дугаар багийн Засаг дарга Ц.Бямбатогтох, 4 дүгээр багийн Засаг дарга Ш.Авирмэд, 11-р багийн Засаг дарга Б.Золбоо, Арвайхээр сумын ИТХурлын даргын жолооч Ө.Ганболд гэсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй мал тоолж ирсэн. Нийт 504 км явж 35 өрхөөс төл бойжилтын мэдээ, төлийн болон зүй бусын хорогдлын мэдээг авч ажиллаа. Энэ оны хагас жилийн байдлаар статистикийн хэлтсээс 31 өрхийн нэр сонгогдож ирснийг 10 хувь мэдээг авч программд шивж оруулан холбогдох А данс, илтгэх хуудсыг сумын мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. | 01-11 сар | 100 |
| | **2.6.** "Багийн хамтарсан баг"-ийн үйл | Төлөвлөгөөний хэрэгжилтий | 98% | 100% | Хамтарсан багийн төлөвлөгөөг 5 бүлэг 9 зорилт арга хэмжээний хүрээнд боловсруулан баталж 98 хувьтай хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг батлах, удирдлага, арга зүйгээр ханган ажиллах. | н хувиар | | | | | |
| | **2.7.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 4 | 3 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө 1 зорилт 7-н арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган багийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 7 зорилтын хэрэгжилтийн бүрэн хэрэгжсэн.<br>Багийн нутаг дэвсгэрт эргүүл хяналтыг 7 хоногт 1 удаа тогтмол хийж үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр, үйлчилгээний газруудад аймаг, сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, мэдээ сурталчилгаа хийн ажиллаж хэвшсэн.<br>Арвайхээр сумын 10-р багийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүдэд хүнсний аюулгүй байдал, стандарт хэмжилзүйн газраас жижиглэн худалдаа түүний үйлчилгээний стандартын тухай зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Уг сургалтанд 10 хүнсний дэлгүүрийн худалдагч оролцсон. "<br>ОДОО Л БОЛЬЁ" арга хэмжээ нь иргэн, аж ахуй нэгж байгууллагад архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, түүний хор хөнөөлийн талаар ойлгуулах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн "Одоо л больё" нэгдсэн арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлигийн хүрээнд Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 9 эрэгтэй, 23 эмэгтэй нийт 32 иргэн оролцсон.<br>Хүний эрхийн коммисийн гишүүд Арвайхээр сумын иргэдэд хүний эрхийн хууль эрхзүйн ойлголт, төрийн | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын чиг үүрэг гэх мэдээлэл чиглэлээр мэдээлэл өгч ажилласан. Тус сургалтад 10 иргэн оролцсон.<br>Дэлхийн тамхигүй өдрийг угтан багийн ажлын алба, хэсгийн ахлагч нар, иргэд, Нарны дөш ӨЭМТөвтэй хамтран өглөө 07-09 цагийн хооронд МТ шатахуун түгээх станцын уулзвараас Ноён хүнсний дэлгүүр хүртэл 2.5 км авто зам дагуу тамхины иш түүлгэж тамхины эсрэг дуу хоолойгоо өргөж, тамхинаас татгалзах олон нийтэд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.<br>Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрөөр 25 иргэд, хүүхдүүдэд гарын авлага тарааж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>"Эх үрсийн баяр"-ыг угтан хүүхдийн тоглоомын талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулдаг Тус ажлыг хийхэд "Бэрс финанс" ББСБ-ын албан хаагчид, 2-р сургуулийн ахлах ангийн 10 хүүхэд, багийн ажлын алба хамтран ажлыг гүйцэтгэсэн.<br>Арвайхээр сумын хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, зорилтот өрхүүдийн аюулгүй байдал гэх мэт хуулийн зөвлөгөө мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан. Арвайхээр сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах салбар зөвлөл, өрхийн эрүүл мэндийн төв, цагдаагийн газартай хамтран багийн нутаг дэвсгэр дээр төрийн үйлчилгээг зөвлөн туслах ажиллах, оройн цагаар эргүүл хяналтын ажлыг зохион байгуулан ажилласан. | | |
| | **2.8.** Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, | Мэдээний тоо | 47 | 47 | Хөдөө аж ахуйн ХАА-1, ХАА-2, ХАА-3, ХАА-5, ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээнүүдийг цаг тухай бүрт хугацаанд нь үнэн зөв гаргаж, судалгааг программд бүрэн шивж ажилладаг. Хагас жилийн мал тооллогын дүнг 1 удаа мал төллөлт, төл бойжилтын мэдээ 8 удаа том малын зүй бусын хорогдлын мэдээг 8 удаа хүнсний ногоо, жимс жимсгэний тариалсан талбайн мэдээ 3 ХАА-7 А,Б тус бүр 1 удаа, ХАА-8 3 удаа ХАА-9 А,Б –г тус бүр 1 удаа, ашиглалтад оруулсан орон сууцны мэдээ 1 удаа тус тус өгч ажилладаг. | 01-11 сар | 100 |

168

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгтгүүлэх. | | | | | | |
| | **2.9.** Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах. | Өгсөн үүрэг даалгавар, арга зүйн зөвлөмжийн биелэлтийн хувиар | 95% | 100% | Багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтныг өдөр тутмын удирдлагаар хангаж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж хугацаатай мэдээ тайлан, өрх, хүн амын цахим санг шинэчлэн бүрдүүлэх, статистик, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон хамтран ажилладаг газруудаас ирсэн мэдээ, судалгааг үнэн зөв гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд, хугацаанд өгөх ажлын үр дүнд хяналт тавьж ажилладаг. Жилийн эцсийн байдлаар 78 төрлийн судалгаа гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн хамтран ажилласан байна. | 01-11 сар | 100 |
| | **2.10.** БИНХ-ыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах, биелэлтийг тайлагнах. | Зохион байгуулсан хурлын тоогоор | 4 | 4 | Багийн иргэдийн Нийтийн Хурал 2024 оны байдлаар 2 удаа хуралдсан байна. Хурлууд ЕБ-ын 5-р сургуулийн урлаг зааланд 2 удаа хуралдаж хурлын бэлтгэл ажлыг маш сайн ханган ажилласан. Хуралд нийт 157 иргэн хамрагдсан.<br>БИНХуралд УИХ-ын гишүүд, Аймаг, сумын Засаг дарга нар, Сумын ИТХ-ын дарга, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, сумын ИТХурлын төлөөлөгч нар, бусад холбогдох мэргэжилтнүүд оролцож хийж хэрэгжүүлсэн ажлуудын тайлан, хийх ажлуудын төлөвлөөг танилцуулж, иргэдээс ирүүлсэн асуултад хариулт өгөн ажилласан.<br>Мөн УИХурлын гишүүд, Засгийн газрын гишүүд орон нутагт ажиллаж, өнгөрсөн 4 жилд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2 удаа тавьсан бөгөөд давхардсан тоогоор 157 иргэн хамрагдсан. УИХурал, Орон нутгийн сонгуультай холбогдуулан 2 удаа хурал зохион байгуулагдсан болно. | 01-11 сар | 100 |
| | | Гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувиар | 90% | 100% | Иргэдээс 20 төрлийн санал хүсэлт гарсан бөгөөд тэдгээр санал хүсэлтийг Арвайхээр сумын ИТХурал, Засаг дарга, түүний Тамгын газар, Хотын Захирагчийн алба болон холбогдох байгууллагад нь уламжилсан. | 01-11 сар | 100 |

169

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэн санал хураах жагсаав. Нийт 11 асуудал эрэмбэллээ. | | |
| **Зорилт 3. “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх”** | | | | | | | |
| 3. | **3.1.** Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг тухай бүр үнэн зөв мэдээллээр хангах. | Үүрэг даалгаврын хэрэгжилт хувиар | 100% | 100% | Байгууллагын удирдлагаас өгсөн цаг хугацаатай үүрэг даалгаврыг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Багийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тухай бүр удирдлагуудад үнэн зөвөөр мэдээллэж шийдвэрлүүлэх саналыг цаг тухай бүрт нь уламжилж ажилладаг | 01-11 сар | 100 |
| | **3.2.** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгөх. | Шийдвэрлэлтийн хувиар | 100% | 100% | Өргөдөл, гомдол нийт 35. Алдарт эхийн 1,2-р одонд орохыг хүссэн 16 буюу 45.7%, гэр болон мөнгөн тусламж дэмжлэг хүссэн 3 буюу 8,5%, Нохой устгалтай холбоотой 2 буюу 5.7%, Эрчим хүчний уналттай холбоотой 6 буюу 17.1%, Төсөл болон бусад зээлд хамрагдахыг хүссэн 2 буюу 5.7%, Худаг усан сантай холбоотой 3 буюу 8.6%, Бохир, цэврийн шугамын гудамжны хотгор, гүдгэртэй холбоотой 3 буюу 8.6 холбоотой санал, өргөдлүүд ирсэн байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй бүгд шийдвэрлэгдсэн. | 01-11 сар | 100 |
| **Зорилт 4. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”** | | | | | | | |
| | **4.1.** Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох | Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн, хувиар | 100% | 100% | 2024 оны жилийн эцсийн байдлаар ирсэн бичгийн баримт бичгийн бүртгэлд 65, явсан баримт бичгийн бүртгэлд 167 баримт бичиг бүртгэгдсэн байна.<br>Аймаг, сумын ЗДТГазар болон бусад байгууллагаас ирсэн 65 баримт бичгээс 58 хариутай бичигт хяналт бүртгэлийн карт нээн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газруудад хүргүүлэх. | Хугацаатай мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн, хувиар | 100% | 100% | Аймаг, сумын ЗДТГазар болон бусад төрийн байгууллага, хувийн хэвшлээс ирсэн судалгаа мэдээ тайланг ирсэн маягт загварын дагуу гарган хугацаанд нь хүргүүлэн ажиллаж хэвшсэн. Энэ онд 78 төрлийн судалгааг гарган холбогдох газар уламжилсан байна. | 01-11 сар | 100 |
| | **4.2.** Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журам, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх. | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | 100% | 100% | Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудыг өдөр тутмын ажил, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон үнэнч шударгаар ажиллаж байгаа бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсгэлгүй албан тушаалын чиг үүргээ шударгаар биелүүлж, иргэд олон нийтээс хууль зөрчсөн ёс зүйн зөрчил үүсгэсэн талаар гомдол санал гараагүй болно. Мөн иргэдээс болон МШУТөвөөр дамжиж гомдол санал ирээгүй. | 01-11 сар | 100 |
| | | Ажлын цагийн хоцрогдол, ашиглалтын хувиар | 100% | 100% | Ажлын цаг ашиглалттай холбоотой зөрчил гомдол гаргаагүй бөгөөд шалтгаангүйгээр ажил таслах, хоцрох, ажлын байранд болон ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэх ёс зүйн зөрчил гаргалгүй, ажлын цагийг зөв зохистой ашиглаж, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажилладаг. | 01-11 сар | 100 |
| | **4.3.**Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | - | 100% | Хяналт, шинжилгээ үнэлгээний дүгнэлт зөвлөмж багийн ажлын албанд ирээгүй байна. | 01-11 сар | 100 |
| | **4.4.** Байгууллагаас зохион байгуулсан | Хамрагдсан арга хэмжээний тоогоор | 4 | 3 | 1. Байгууллагаас зохион байгуулсан ажил арга хэмжээнд цаг тухай бүр идэвх санаачилгатай оролцож хэвшсэн.<br>2. Гандантүнцоглин хийдтэй хамтран зохион | 01-11 сар | 100 |

171

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох. | | | | байгуулсан галын их тахилгад багийн 51 иргэнийг хамруулж хамтран ажилласан. 2. Монгол бичгийн багц сургалтад хамрагдаж дунд шатны мэдлэг эзэмшиж сертификатаа гардан авсан.<br>3. Аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран зохион байгуулсан бие бялдрын сорилгод багийн иргэдээ уриалж хамгийн түрүүнд оролцож сорилго өгсөн.<br>4. Өсвөрийн бөхийн улсын аварга шалгаруулах барилдаан зохион байгуулагдахад 2 аймаг хариуцаж тэмцээн уралдаан, арга хэмжээнд нь хариуцлагатай байлгаж амжилттай оролцуулсан. | | |
| | **4.5.** Байгууллага, багт туршлага болохуйц шинэлэг ажлыг зохион байгуулах. | Арга хэмжээний тоогоор | 3 | - | 1.Дэлхийн тамхигүй өдрийг угтан багийн ажлын алба, хэсгийн ахлагч нар, иргэд, Нарны дөш ӨЭМТөвтэй хамтран өглөө 07-09 цагийн хооронд МТ шатахуун түгээх станцын уулзвараас Ноён хүнсний дэлгүүр хүртэл 2.5 км авто зам дагуу тамхины иш түүлгэж тамхины эсрэг дуу хоолойгоо хүргэж, тамхинаас татгалзах олон нийтэд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.<br>2. Жил бүрийн 6 дугаар сарын 1 ний өдөр багийн хүүхдүүдийн дунд өргөн хүрээтэй хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн. Уламжлал ёсоор зохион байгуулахаар төлөвлөж байна. | 01-11 сар | 100 |

**Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| "Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй | | | | | | | |

172

| хөгжүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хувь хүний хөгжил, SUPER JAMP сургалтанд хамрагдах, Илтгэх урлагийн сургалтад хамрагдах | Сертифкаттай сургалтад хамрагдах | - | 10цаг | SUPER JAMP сургалтад хамрагдаж байгаад эрүүл мэндийн асуудлаас болоод түр завсарласан байгаа. 2-р хагас жилд суралцаж төгсөнө.<br>Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сертификаттай 18 цагийн сургалтад хамрагдсан | I-IV улиралд | 100% |
| 2. | Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлж уншиж бичих чавдараа дунд түвшинд хүргэх | Хамрагдсан сургалтын тоогоор | | 10 цаг | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III, "Хүмүүн бичигтэн хөтөлбөрийн хүрээд найман удаагийн хичээлээр үзэж судлан амжилттай суралцлаа.<br>Долоо хоног бүрийн даваа, лхагва, баасан гарагт үндэсний бичгийн сургалтыг мэргэжлийн багшаас авч, мэдлэг чадвараа дээшлүүлсэн юм. Энэ удааги йн сургалтаар үндэсний бичгээ сэргээн санах, бататгах, уншлагаа сайжруулах, компьютерын хэрэглээний программ дээр бичиж сурах зэрэг хичээлийг үзэж судлан дахин сорил шалгалтыг өгч батламжаа гардан авлаа.<br>Цаашид үндэсний бичгийн мэдлэг чадвараа бататгаж, албан хэрэгцээндээ нэвтрүүлж, тогтмол хэрэглэж байх зорилт тавин ажиллаж байна. | I-IV улиралд | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАГИЙН ЗАСАГ ДАРГА ........................ / Ц.БЯМБАТОГТОХ/ 2024.11.22

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

173